

## НЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газар нь Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 42 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т тусгагдсан дараахь эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлж байна.

### Үйл ажиллагааны эрхэм зорилго:

Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулахад оршино.

### Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Худалдан авах ажиллагааны газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна:

- Худалдан авах ажиллагааны тогтолцоо, удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан төлөвлөж, зохион байгуулан хэрэгжүүлэх, тайлагнах;
- Худалдан авах ажиллагаанд менежментийн шинэлэг чиг хандлага, ур чадварыг хэрэгжүүлэх;
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;
- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон нутгийн нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар хангах;

Тус агентлаг нь тухайн жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхдээ дээр дурдсан үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтыг хангах хүрээнд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2014 оны Үндсэн чиглэл, холбогдох үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараахь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг баримтлав.

### Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Худалдан авах ажиллагааны үр ашигтай тогтолцоог бий болгон хөгжүүлэх;
- Худалдан авах ажиллагааны талаарх төрийн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулах;
- Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан төлөвлөж, зохион байгуулан хэрэгжүүлж, тайлагнах;
- Худалдан авах ажиллагаанд менежментийн шинэлэг чиг хандлага, ур чадварыг ашиглах;
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх.

Дээр дурдсан бодлого, үйл ажиллагааны зорилт, чиглэлийг хэрэгжүүлэх ажлуудыг агентлаг, нэгжийн 2014 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө,

Төсвийн шууд захирагчийн болон хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжилтийг хагас жилээр дүгнэн, нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг сар, улирлаар тодотгож, биелэлтийг тооцон ажиллаж байна.

Мөн түүнчлэн, Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвын санаачилгаар 2013 онд “Сахилга, хариуцлага” сэдвийн дор зохион байгуулсан “Ард түмэн Та – Хаан” үндэсний форумаас гарсан уриалгыг 2014 оны үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх, Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 01 тоот тушаалаар батлагдсан агентлагийн 2014 оны ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлтийг ханган ажиллахаар “Бид манлайлна” гэсэн оны зорилтыг тавин ажиллаж байна. Ийнхүү сахилга, хариуцлагыг дээшлүүлж, манлайллыг өндөржүүлэх ажлыг Газрын дарга буюу Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний хавсралтаар батлагдсан “Байгууллагын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлж байна.

Ингээд 2014 оны зорилт, үйл ажиллагааны эхний хагас жилийн тайланг дор дурдсанаар дэлгэрэнгүй тайлагнаж байна. Тайланд тусгасан мэдээ, мэдээллийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ээс 07 дугаар сарын 16-ны өдрийн хугацааг хамруулав.

## **ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН**

### **2.1. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН АКТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР**

Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үнэлгээний хорооны тайлан, гэрээ байгуулах, татгалзах мэдэгдэл, захиалагчдад өгөх зөвлөмж, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ, тендерт шалгарсан компаниудын мэдээллийг олон нийтэд мэдээлэх материал зэрэг худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийн төслийг хууль зүйн талаас хянаж, Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэгтэйгээр байгуулагдсан үнэлгээний хороодод энэ талаар заавар, зөвлөгөө өгч ажиллалаа. Тайлангийн хугацаанд тус газрын Хууль зүйн хэлтсээс 2014 онд хэрэгжүүлэх 118 төсөл, арга хэмжээний 193 багц ажлын (06 дугаар сарын 25-ны байдлаар) 138 буюу 61.8 %, эрх шилжиж ирсэн 15 төсөл, арга хэмжээний 25 багц ажлын 8 буюу 32 %-ийн тендер шалгаруулалтын тайлан, гэрээ байгуулах мэдэгдэл, татгалзах мэдэгдэл, зөвлөмж, тендерийн баталгаа чөлөөлөх тухай зэрэг 767 албан бичиг, 101 гэрээний төсөл, ХААГ-ын даргын тушаалын 30 төсөл, нийт 898 баримт бичгийг хууль зүйн талаас хянаж, зөвлөгөө өгөв.

Тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг тогтмол хөтөлж, тендерт шалгарсан гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн санг үүсгэсэн бөгөөд уг мэдээллийн санд 2013 онд гэрээ байгуулсан 242 аж ахуйн нэгжийн, 2014 онд гэрээ байгуулсан 113 аж ахуйн нэгжийн мэдээллийг бүртгээд байна. 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 113 аж ахуйн нэгжтэй 113 багц гэрээ байгуулснаас 1 гэрээ байгуулсан ААН-ийн тоо - 93, 2 гэрээ байгуулсан ААН-ийн тоо - 16, 3 гэрээ байгуулсан ААН – 3, 5 гэрээ байгуулсан ААН - 1 бүртгэгдэв.

Худалдан авах ажиллагааны газрын албан хэрэг хөтлөлтийг сайжруулах, мэргэжилтнүүдийн бичиг хэргийн боловсруулалтын чадварыг дээшлүүлэх, гарын авлага материалаар хангах, үнэлгээний хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Худалдан авах ажиллагааны газрын албан хэрэг хөтлөлт, архивын журам”, “Загвар батлах тухай”, “Гэрээ байгуулах ажиллагааг эрчимжүүлэх тухай” тушаалын төслүүдийг боловсруулан Даргын зөвлөлийн хурлаар

хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байгаа нь нийт мэргэжилтнүүд, үнэлгээний хороодын гаргаж байгаа албан бичиг нэг жишиг загварт орж, тендер шалгаруулалттай холбоотой гарах маргаан, гомдлыг бууруулах чухал үр дүнтэй ажил боллоо.

Тендерт шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн 81 тендерийн материалыг [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn) сайтад байрлуулж, олон нийтэд мэдээлэхийн өмнө нэг бүрчлэн хянаж хууль зүйн зөвлөгөө өгч ажиллав. Мөн тендерийн үр дүнг [meps.gov.mn](http://meps.gov.mn) сайтаас хэрхэн харах талаарх зөвлөмж, танилцуулгыг бэлтгэн, Шадар сайдад танилцуулах агентлагийн даргын мэдээлэлд хавсаргасан бөгөөд уг танилцуулгыг [e-tender.mn](http://e-tender.mn) сайтад байршуулж, олон нийтэд хүргэв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яамтай хамтран боловсруулсан бөгөөд Шадар сайдын Худалдан авах ажиллагаа хариуцсан зөвлөх Ж.Хүрэлсүхээс ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад засвар оруулан эцэслэн бэлтгэж, Шадар сайдад 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдөр танилцуулав. Орон нутгийн 31 нэгжид уг хуулийн төслийг хүргүүлэн танилцуулж, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дундговь аймаг, Баянгол, Налайх дүүргүүдээс ирүүлсэн саналыг төсөлд тусгах арга хэмжээ авав. Мөн Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулсан “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөв. Тайлангийн хугацаанд Зөвшөөрлийн тухай, Гэмт хэргийн тухай, Хөдлөх болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалтыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд өгөх саналыг боловсруулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэв.

2014 оны 03 дугаар сарын 07-ны өдөр 34 төрийн бус байгууллагын 59 төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, худалдан авах ажиллагаанд салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулах эрх зүйн үндэслэл, тэдний үүрэг, оролцооны талаар ярилцан, тэдгээр ТББ-тай “Худалдан



ТББ-ын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр

авах ажиллагаанд салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг олон нийтийн хяналт тавих чиг үүрэгтэйгээр оролцуулан хамтран ажиллах гэрээ”-г байгуулан ажиллаж байна. Гэрээ байгуулсан ТББ-ын төлөөлөл ХААГ-аас зохион байгуулж байгаа тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд томилогдон олон нийтийн хяналт тавих үүрэгтэйгээр ажиллаж байна. Уг гэрээний 4 дүгээр зүйлд худалдан авах ажиллагаанд оролцохдоо авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар тодорхой заалтуудыг тусган холбогдох хуулийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд төрийн бус байгууллагын төлөөлөлтэй холбоотой ашиг сонирхлын зөрчлийн талаар ямар нэгэн гомдол, санал гараагүй байна.

Шадар сайдын ажлын алба, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Оюуны өмчийн газартай хамтарсан уулзалтыг 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулан худалдан авах ажиллагаанд оролцож буй оюуны өмчийн эрх авсан компаниудын эрхийг хамгаалах, гэрээ шууд байгуулах нөхцөл үүсэх, энэ


нөхцөл нь өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа эсэх талаар хэлэлцэн ярилцаж, уг уулзалтаас хамтарсан зөвлөмж гаргахаар шийдвэрлэн зөвлөмжийн төслийг боловсруулах талаар холбогдох байгууллагуудаас санал авч байна.

Мөн 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Сангийн яамны Хууль, Худалдан авах ажиллагааны бодлогын газрын дарга н.Хангай, БХЗГ-ын дарга нартай тус агентлагийн зүгээс зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, худалдан авах ажиллагааны талаар гарч байгаа гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцаж, ХААГ-ын зүгээс энэ талаар тулгамдаж байгаа асуудлыг танилцуулав.

Тайлангийн хугацаанд захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандаж гарсан нэхэмжлэлийн дагуу 12, давж заалдах шатны шүүхэд 5 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон оролцлоо.

2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар худалдан авах ажиллагааны 40 төсөл, арга хэмжээнд 49 гомдол гарсан нь энэ онд хэрэгжүүлэх нийт 118 төсөл, арга хэмжээний 193 (тухайн үеийн тоогоор) багц ажлын 25,4 % болж байна. Эдгээрийг хандсан байгууллага, шийдвэрлэлтийн явцын байдлаар нь тус тус доорх графикаар харуулав.

*Гомдол, түүний шийдвэрлэлт*



Ерөнхий гэрээний тендерийн жишиг баримт бичгийн төслийг боловсруулсан бөгөөд хууль эрх зүйн талаас холбогдох саналыг тусгахаар болсон боловч Сангийн яамны 2014-04-24-ний өдрийн 5/2130 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлага үүссэн тул тодорхой судалгаануудыг бүрэн хийхээр ажиллаж байна. Энэ хүрээнд ЕСБХБанкны санхүүжилт, мэргэжилтний дэмжлэгтэйгээр өргөн хэрэглээний шатахуун, бичгийн цаасны эрэлт, нийлүүлэлтийн судалгааг улсын хэмжээнд эхлүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Аж ахуйн нэгжийн чансаа тогтоох” талаарх асуудлыг агентлагийн төлөвлөгөө, удирдлагын үр дүнгийн гэрээнд тусган холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна. Энэ хүрээнд Дэлхийн банкны “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”-ийн хүрээнд тус газарт энэ оны 07 дугаар сараас эхлэн 2 мэргэжилтнийг ажиллуулж, ХААГ-аас 2013-2014 онд зарласан тендерт гүйцэтгэгчээр шалгарсан компаниудын чадавхийн судалгаа хийж байна. Энэхүү судалгааны үр дүнд тендерт оролцогч компаниудын чансаа тогтоох боломж үүсэх юм.

Сангийн Сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-д 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Сангийн яаманд өгч, улмаар тусгуулан мөрдөж байна.

Худалдан авах ажиллагааны талаарх төрийн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулан, бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн актын

хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол баталсан “Захиргааны байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан хугацаа, хуваарийн дагуу 2013 оны жилийн эцэс, 2014 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, Шадар сайдын ажлын албанд мэдээлж ажиллав. Хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнтэй холбоотой дараахь мэдээ, мэдээлэл, тайлангуудыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв:

- 2014 оны гарсаар сар бүр, нийт 6 удаа Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” цахим хуралд Шинэчлэлийн Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг гарган тогтоосон хугацаанд холбогдох мэдээллийн хамт хүргүүлсэн.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан холбогдох арга хэмжээний талаар судалж, ШСАА-нд 2014-03-05-ны өдрийн 1/278 тоот албан бичгээр мэдээлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2013 оны жилийн эцсийн байдлаар гарган ШСАА-нд 2014-03-11-ний өдрийн 1/327 тоот албан бичгээр хүргүүлэв.
- Хяналтад авсан Засгийн газрын тогтоол, шийдвэрийн холбогдох заалтын 2013 оны жилийн эцсийн биелэлтийн дүн мэдээг гаргаж, ШСАА-нд 2014-01-15-ны өдрийн 1/44 тоот албан бичгээр хүргүүлсэн. Нийт 31 шийдвэрийн 38 заалтын хэрэгжилт 93,9%-ийн явцтай дүн гарсан бөгөөд тэдгээрээс 20 шийдвэрийн 25 заалтыг журамд заасны дагуу дээд шатны байгууллагад мэдээлж байх хяналтаас хасах саналыг боловсруулан хүргүүлсэн. Мөн Худалдан авах ажиллагаатай холбоотой УИХ-ын 2013 оны 58 дугаар тогтоолын хэрэгжилтийг 2013 оны жилийн эцсийн байдлаар гарган ЗГХЭГ-ын ХШҮДАГ-т 2014-04-03-нд цахим хэлбэрээр хүргүүлэв.
- 2014 оны эхний хагас жилийн мэдээ, тайланг гаргаж, 2014-06-18-ны өдрийн 1/1746 тоот албан бичгээр ШСАА-нд хүргүүлэв. Үүнд:
  - ✓ 2014 оны эхний хагас жилд сахилга, хариуцлага, манлайллыг өндөржүүлэх чиглэлээр хийсэн онцлох ажил, үр дүн,
  - ✓ Газрын даргын үр дүнгийн гэрээний биелэлт буюу газрын 2014 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт,
  - ✓ Холбогдох эрх зүйн актын биелэлт (Дүнгийн товчоо, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, Хяналтаас хасуулах шийдвэр, заалтын жагсаалт),
  - ✓ УИХ-ын тогтоолын биелэлт,
  - ✓ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт,
  - ✓ Шадар сайдын шийдвэрийн хэрэгжилт,
  - ✓ Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилт.

“Монгол Улсын Засгийн газрын 2014 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө”-нд тусгах саналыг боловсруулж, ЗГХЭГ-т 2014-01-21-ний өдрийн 1/85 дугаар албан бичгээр, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-д тусгах саналыг боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлын хэсгээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж, ШСАА, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд 2014-03-21-ний өдрийн 1/420 тоот албан бичгээр тус тус хүргүүлэв.



2014 оны хагас жилийн байдлаарх бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн явцын дүнг дор хүснэгтээр харуулав. Нийт 28 бодлого, шийдвэрийн 59 заалтын хэрэгжилтийг зохион байгуулж дүгнэхэд дунджаар 77,6 %-ийн гүйцэтгэлийн явцтай байгаагаас бөгөөд улмаар жилийн эцэст бүрэн хэрэгжих боломжтой.

*Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн явц, 2014 оны эхний хагас жилийн байдлаар*

№	Бодлого, шийдвэр		Хэрэгжилтийг тооцсон заалт	Хэрэгжилтийн явц /%/	
	Нэр	Тоо			
<b>Нэг. Бодлогын баримт бичиг:</b>					
1	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого		ЗГ-аас баталсан журмын дагуу бүтэн жилээр тооцно.		
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө		1	3	76,7
3	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл		1	24	89,1
4	Үндэсний хөтөлбөр		ЗГ-аас баталсан журмын дагуу бүтэн жилээр тооцно.		
<b>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дүн</b>			<b>2</b>	<b>27</b>	<b>82,9 %</b>
<b>Хоёр. Холбогдох эрх зүйн акт:</b>					
1	УИХ-ын тогтоол		3	4	75,0
2	Ерөнхийлөгчийн зарлиг		-	-	-
3	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж		-	-	-
4	Засгийн газрын тогтоол		10	13	73,9
5	Ерөнхий сайдын захирамж		1	1	70,0
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл		10	12	72,7
7	Шадар сайдын тушаал		2	2	70,0
<b>Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн дүн</b>			<b>26</b>	<b>32</b>	<b>72,3 %</b>
<b>НИЙТ ДҮН</b>			<b>28</b>	<b>59</b>	<b>77,6 %</b>

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан худалдан авах ажиллагаатай хамааралтай нийт 2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 5 арга хэмжээний хэрэгжилтийг бүртгэл хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Эдгээр 5 хэрэгжүүлэх арга хэмжээнээс 17.1 ба 17.2 дахь арга хэмжээг ХААГ-т хэрэгжүүлэх боломжгүй байгаа хэрэгжиж байгаа нийт 3 заалтын хэрэгжилтийн явц 2014 оны эхний хагас жилийн байдлын дүнгээр дунджаар 76,7 %-ийн дүнтэй байна.

Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд ХААГ-ын нэрээр шууд хамааруулан даалгасан заалт батлагдаагүй байгаа ч холбогдох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлд хамааралтай ХААГ-т зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явцын мэдээллээр хэрэгжилтийг гарган мэдээлэв. Нийт 4 бодлогын чиглэлийн хүрээний 14 зорилтод хамаарах 24 заалт (хэрэгжүүлэх арга хэмжээ)-ын хэрэгжилтийн явц эхний хагас жилийн байдлаар 89,1%-тай байна.

Монгол Улсын Засгийн газрын (Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл) нийт 21 шийдвэрийн 26

заалтын хэрэгжилтийн явц дунджаар 72,2 %-тай байгаа бөгөөд тэдгээрээс хэрэгжих хугацаа дууссан, хэрэгжилт тогмолжсон нийт 9 шийдвэрийн 11 заалтыг дээд шатанд мэдээлэх хяналтаас хасах саналыг ЗГХЭГ-т уламжлуулахаар ШСАА-нд хүргүүлэв. Худалдан авах ажиллагаатай холбоотой Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гараагүй ба Үндэсний хөгжлийн цогц бодлого, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох журмын дагуу бүтэн жилээр хэрэгжилтийг тооцон мэдээлэх тул эхний хагас жилийн дүнд тусгагдаагүй.

## 2.2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газар нь төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журам”-ын хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 408 дугаар тогтоолоор ХААГ-т 129 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар батлагдсан тэдгээрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллалаа. Үүний хүрээнд Худалдан авах ажиллагааны 2014 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулан Шадар сайдаар батлуулсны зэрэгцээ төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний захиалагч буюу төсвийн Ерөнхийлөн захирагч бүртэй хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Үнэлгээний хороонд ХААГ, ТББ-аас оролцох төлөөллийг санамсаргүй түүвэрлэн сонгох арга хэрэглэн сонгож байгаа нь олон нийтээс гарч болох үндэслэлгүй гомдол, гүтгэлгээс зайлсхийж, төрийн худалдан авалтыг будлиангүй, шударга зохион байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой ажил болж байна. ХААГ-аас эхний хагас жилийн байдлаар 137 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах 130 үнэлгээний хороо байгуулан тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд тэдгээрт нийт 25 төрийн байгууллагын давхардсан тоогоор 262 төлөөлөл, 62 төрийн бус байгууллагын давхардсан тоогоор 242 төлөөлөл сонгогдон ажиллаж байна. Нэг үнэлгээний хороонд 2 доошгүй ТББ, мэргэжлийн холбоодын төлөөллийг заавал оролцуулан, олон нийтийн хяналт тавих чиг үүрэгтэйгээр оролцох чиглэл зөвлөмж өгч, гэрээ байгуулан ажилласан.

ХААГ-аас зохион байгуулж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шаардлагатай ТЭЗҮ, төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг захиалагч төсвийн ерөнхийлөн захирагчийн байгууллагаас шуурхай ирүүлэх талаар оны эхнээс эрчимтэй арга хэмжээ авч ажиллав. Зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар ирүүлэхгүйгээс ХААГ-т зохион байгуулах ажлыг удаашруулж байгаа захиалагч байгууллагын талаар Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” цахим хуралд сар бүр мэдээлж, ЗГХЭГ, Шадар сайдаар уламжлуулан захиалагчаас шаардан ажиллав.


ХААГ-ын зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээллийн бааз үүсгэн түүнийг холбогдох мэдээ, тайлан, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, авах арга хэмжээг тодорхойлох, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг удирдлагын менежментэд ашиглан, худалдан авах ажиллагааны явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийн ажиллаж байна.

Тайлант хугацаанд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны явц, үр дүнгийн талаар дор тайлагнав.

**А. ХААГ-т зохион байгуулахаар төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны явц.** Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 408 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ХААГ-т 129 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг өгөгдсөн. Эдгээр төсөл, арга хэмжээнүүд нь 233 багц ажил болон задарсан ба гүйцэтгэл, үр дүнг 2014 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар харуулбал,

1. Засгийн газрын 23, 60, 95, 105 дугаар тогтоолуудаар нийт 4 ажил хасагдаж төсвийн ерөнхийлөн захирагч БШУЯ, ЭХЯ, БХБЯ-нд шилжсэн.
2. 2014 оны төсвийн тодотголоор ССАЖЯ-ны 2 ажил, УУЯ-ны 1 ажил, ХЯ-ны 3 ажил, ЭХЯ-ны 1 ажил, нийт 7 ажил тус тус хасагдаж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт эрх шилжиж очсон.
3. Засгийн газрын 2014 оны 24, 29 дүгээр тэмдэглэлээр 8 төсөл, арга хэмжээ нэмэгдсэн.
4. Дээрх өөрчлөлтийн дүнд, ХААГ-т нийт 126 төсөл, арга хэмжээний 207 багц ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.

*Худалдан авах ажиллагааны явц, 07 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар*



Дээрх явцын байдлаас дүгнэхэд, Засгийн газрын 2013 оны 408 дугаар тогтоолоор баталсан, ХААГ-т худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдах төсөл, арга хэмжээний 93,0 %-д нь тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, хэрэгжсэн буюу хэрэгжих шатанд байгаа бол харин нийт ажлын 74,0 %-д төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан буюу холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт гэрээ байгуулах мэдэгдлийг тус газраас хүргүүлэн ажиллаад байна.

**Б. Эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааны явц.** Түүнчлэн Төсвийн ерөнхийлөн захирагч нараас 18 төсөл, арга хэмжээ буюу багц ажил болон задарснаар нийт 59 багц ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хүсэлт ирүүлсний дагуу эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааг ХААГ-т зохион байгуулж байна.

Эрх шилжиж ирсэн ажлын явц, 07 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар




- 33 багц ажлын буюу нийт ажлын 55,9 %-д гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан,
- Тендер шалгаруулалтын ажил явагдаж байгаа (тендер зарласан, үнэлгээ хийж байгаа) 23 багц ажил буюу нийт ажлын 38,9 %,
- 3 (5,1 %) багц ажлын зураг, төсөв, ажлын даалгаврыг холбогдох захиалагч буюу төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлээгүйгээс хүлээгдэж байна.


**В. ХААГ-т зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны гэрээ байгуулсан дүн, хэмнэлт.** 2014 онд 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар, 2014 онд хэрэгжүүлэх нийт 116 төсөл, арга хэмжээний 193 багц ажлаас 51 (44.0%) төсөл, арга хэмжээний 105 (54.4%) багц гэрээ, эрх шилжиж ирсэн 15 төсөл, арга хэмжээний 25 багц ажлаас ажлаас 3 (20.0%) төсөл, арга хэмжээний 8 (32.0%) багц гэрээ байгуулагдсаныг Хуулийн хэлтэст бүртгэж авсан. Өөрөөр хэлбэл, 2014 онд гэрээ байгуулагдвал зохих нийт 131 төсөл, арга хэмжээний 218 багц ажлаас (эрх шилжиж ирсэн ажлыг оруулж тооцсоноор) нийт 54 (41.2%) төсөл, арга хэмжээний 113 (51.8%) багц гэрээг байгуулсан үр дүнтэй байна. Энэ нь 108,014.96 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажилд 98,889.78 тэрбум төгрөгийн гэрээг байгуулан 7,643.21 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон дүнтэй байна.

**Г. Орон нутагт зохион байгуулагдаж байгаа худалдан авах ажиллагааны явц.** 2014 онд аймаг, нийслэл, дүүргийн Худалдан авах ажиллагааны 31 нэгжид нийт 526.2 тэрбум төгрөгний 2163 (100%) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаас эхний хагас жилийн байдлаар 428,6 тэрбум төгрөгний 1653 (76 %) төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан ба 96 тэрбум төгрөгний 510 (24%) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй хүлээгдэж байна.

Орон нутгийн ХАА-ны нэгжийн мэдээ, 2014 оны эхний хагас жил



Орон нутгийн ХАА-ны нэгжийн мэдээ



Орон нутгийн ХАА-ны нэгжийн мэдээ



Тайлант хугацаанд холбогдох хуулийн дагуу 2013 оны жилийн эцсийн болон 2014 оны 1 дүгээр улирал, эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны явцын тайлан, мэдээг гарган Сангийн яам, Шадар сайдын албанд хүргүүлэн мэдээлэв. Шадар сайдын агентлагийн дарга нарын шуурхай хуралд энэ талаарх мэдээллийг бэлтгэн танилцуулж, Шадар сайдаас өгсөн үүрэг, чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллав.

### 2.3. ЦАХИМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлэхээр тусгасан зорилтыг хэрэгжүүлээр ХААГ-аас тайлант жилд ХААГ-т зохион байгуулах тендер шалгаруулалтын 80-аас доошгүй хувийг, орон нутагт зохион байгуулах тендер шалгаруулалтын 10-аас доошгүй хувийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөсөн ба ХААГ нь худалдан авах ажиллагааг 100 % цахим хэлбэрээр зохион байгууллаа. 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Нийслэл, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг, Хан-Уул дүүрэг цахим хэлбэрээр 37 хүртэлх хувийг (Хүснэгтээр харуулав) зохион байгуулсан үр дүнтэй байна.

21 аймгийн Засаг дарга нарт орон нутгийн нэгжүүдийн Цахим худалдан авах ажиллагааг зохион байгуулах нөхцөл бүрдүүлэх талаар анхаарах асуудлаар ХААГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 1/217 тоот, орон нутгийн нэгжүүдэд 2014 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 20-иос доошгүй хувийг цахимаар зарлах тухай ХААГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 1/218 тоот албан албан бичгийг тус тус хүргүүлсэний дагуу 31 нэгж цахим тендер зохион байгуулах хувийн нууцлалын PKI код авсан.

## Цахим худалдан авалт зохион байгуулсан нэгжүүдийн мэдээлэл

№	Аймгийн нэр	2014 онд зохион байгуулагдах нийт худалдан авалтын тоо	2014 оны 1 дүгээр улиралд		2014 оны 06 сарын 16-ны байдлаар	
			Зохион байгуулагдсан тоо	Зохион байгуулагдсан хувь	Зохион байгуулагдсан тоо	Зохион байгуулагдсан хувь
1	Нийслэл	212	20	18	41	19
2	Архангай	59	-	-	-	-
3	Баян-Өлгий	65	-	-	4	6
4	Баянхонгор	64	-	-	-	-
5	Булган	55	-	-	-	-
6	Говь-Алтай	82	-	-	-	-
7	Говьсүмбэр	29	-	-	-	-
8	Дархан-Уул	75	8	11	15	20
9	Дорнод	95	-	-	1	1
10	Дорноговь	83	-	-	2	2
11	Дундговь	77	-	-	-	-
12	Завхан	50	-	-	8	16
13	Орхон	233	-	-	-	-
14	Өвөрхангай	32	2	6	7	23
15	Өмнөговь	82	-	-	-	-
16	Сүхбаатар	49	4	9	18	37
17	Сэлэнгэ	45	-	-	-	-
18	Төв	51	-	-	1	2
19	Увс	64	3	5	8	13
20	Ховд	86	4	5	11	13
21	Хөвсгөл	70	-	-	1	1
22	Хэнтий	62	5	9	17	27
23	Дүүргүүд	657	-	-	2	0
<b>НИЙТ</b>		<b>2376</b>	<b>46</b>		<b>136</b>	

Харин албадын үйл ажиллагаа, зохион байгуулалт, материаллаг бааз, ажиллах нөхцөл болон бусад шалтгааны улмаас Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймгуудад худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах талаар тодорхой үр дүнтэй ажил хийгдээгүй байгаад дүгнэлт хийж, Худалдан авах ажиллагааны албыг бэхжүүлэх, албан хаагчдыг сургах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэх, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэхь заалтыг хэрэгжүүлж, шалгарсан болон шалгараагүй үндэслэлийг вэб хуудаст ил тод мэдээлж ажиллахыг анхааруулсан ХААГ-ын даргын 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 1/1765 тоот албан бичгийг 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн дээр зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газрын Цахим худалдан авах ажиллагааны хэлтсээс Цахим худалдан авах ажиллагааны системийг хөтөлж, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэн, түүний хэвийг ажиллагааг хангахад онцгой анхааран ажиллаж байна.

Цахим худалдан авах ажиллагааны системийг 2013 онд Монгол банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, ХААН банк, Төрийн банк, Хас банк, Капитрон банк, Капитал банкуудын мэдээллийн системтэй интернэтэд суурилан холбож, тендер зарласан өдрийн валютын ханшны мэдээлэл, тендер



оролцогчдын тендерийн баталгааны мэдээлэл, тендерт оролцох хураамжаа төлсөн эсэх тухай мэдээллийг тус тус цахим хэлбэрээр солилцож байсан. Он гарсаар Улаанбаатар хотын банкны системтэй шинэ холболт үүсгэсэн ба Үндэсний хөрөнгө оруулалтын банк болон Чингис хаан банкны системтэй холболт хийхээр бэлтгэж байна. Сангийн Сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер

шалгаруулалт зохион байгуулах журам”-д заасны дагуу арилжааны банктай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгууллаа. Мөн цахим тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны төлөөллүүдийг оролцуулсан уулзалтыг зохион байгуулж, цахим тендерийн баталгаа хэрхэн гаргах тухай заавар зөвлөмжийг өгсөн.

Түүнчлэн Татварын ерөнхий газрын мэдээллийн системтэй холбогдож тендерт оролцогчдын татвар төлөлтийн мэдээлэл, борлуулалтын орлогын мэдээллийг цахим хэлбэрээр магадлах програм хангамжийн шийдлийг боловсруулж туршсан. “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-д заасны дагуу Татварын ерөнхий газартай хамтран ажиллах, цахим мэдээлэл солилцох гэрээ байгуулах шаардлагатай байгаа төдийгүй цахим худалдан авах ажиллагааны системийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн системтэй Үндэсний Дата төвөөр дамжуулан холбож цахим мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх шаардлагатай байгаа асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой Засгийн газрын 2014 оны 02 дугаар тэмдэглэлээр өгсөөр үүргийг хэрэгжүүлэхээр дээрх байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



Цахим худалдан авах ажиллагааны системийн цахим мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох системийг бий болгох, Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шатыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор уг системийн мэдээллийн санг сервер, тоног төхөөрөмжийн хамт 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Үндэсний Дата Төвд шилжүүлэн байршуулав. Тус системийг Үндэсний Дата Төвд шилжүүлэн байршуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай арга хэмжээг авч, төслийг хэрэгжүүлэгч Samsung SDS компанийн дэмжлэгтэйгээр 2 ширхэг Watchguard 525 галт ханын төхөөрөмжийг БНСУ-аас захиалан авчруулж суурилуулав.

Цахим худалдан авах ажиллагааны системийг ашиглан улсын хэмжээнд тайлант хугацаанд (06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар) нийт 335 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан ба түүнд 516 ААН 1083 тендерийг ирүүлж оролцсон. ХААГ-аас нийт 182 удаагийн, орон нутгийн нэгжүүд нийт 153 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Эхний хагас жилийн байдлаар цахим тендер шалгаруулалттай холбоотой зарим статистикийг дор дурдвал:

- Цахим системд бүртгэгдсэн ААН-ийн тоо – 1283,
- Цахим системд бүртгэгдсэн хувийн нууцлалын код – 1723,

- Хувийн нууцлалын код олгосон тоо – 2085,
- Цахим системд бүртгэгдсэн захиалагч байгууллагын тоо – 42.

Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шатны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж байгаа ба “ИнтерАктив” ХХК-д тус компаний ирүүлсэн санхүүгийн саналыг нээх тухай мэдэгдлийг 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлж, 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдөр санхүүгийн саналын нээлтийг хийсэн.

## 2.4. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР

### 2.4.1. Сургалт зохион байгуулах чиглэлээр

2014 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, суурь мэдлэг олгох сургалтыг Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв", "Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв", "Монголын төсвийн мэргэжилтнүүдийн холбоо", “КМТСургууль”, МУИС-ын Бизнесийн сургуулийн дэргэдэх “Бизнес төв” зэрэг эрх бүхий ТББ-уудтай хамтран 106 удаа зохион байгуулж, 2197 иргэн гэрчилгээ авсан. Үүнээс хөдөө орон нутагт давхардсан тоогоор 28 удаа сургалт зохион байгуулж, нийт 2055 хүн хамрагдсанаас 1022 оролцогч амжилттай суралцаж гэрчилгээ авав.



Цахим худалдан авах ажиллагааны системийн талаарх мэдлэг олгох сургалтыг 7 хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагуудын 15:00 цагт тогтмол зохион байгуулж хэвшсэн бөгөөд уг сургалтанд нийт 897 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан.

Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжүүдэд цахим тендер шалгаруулалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангахад анхааран ажиллаж байна. Дорнод, Хэнтий, Говь-Алтай, Өвөрхангай аймгуудад “Цахим худалдан авах ажиллагаа” сэдэвт сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 210 иргэн, ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан.

2014 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газартай хамтран эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, компаниудын төлөөлөл, нийт 40 гаруй хүнд цахим худалдан авах ажиллагааны системд хэрхэн бүртгүүлж, цахим тендерт оролцох болон цахим худалдан авах ажиллагааны давуу тал, анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, аж ахуйн нэгжийн төлөөллийн сонирхсон асуултанд хариу өглөө.





Мөн 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газартай хамтран тус газрын салбар, нэгжүүдийн төлөлөөлөлд Цахим худалдан авалт сэдэвт илтгэл танилцуулав.

Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдыг хамруулсан бүсчилсэн сургалтыг Хангай, Төв, Баруун, Зүүн, Улаанбаатар гэсэн 5 бүсэд зохион байгуулахаар төлөвлөн удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулсан ба ЕСБХБ-аас санхүүжилтийн асуудлаар дэмжлэг авахаар хандаад байна. Хөрөнгө, санхүүжилтийн асуудал дутагдалтайгаас эхний хагас жилд зохион байгуулагдаагүй ийнхүү хүлээгдэж байна.

#### 2.4.2. Орон нутгийн нэгжүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах чиглэлээр



2014 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Говьсүмбэр аймгийн Худалдан авах ажиллагааны албаны албан хаагчид, аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагийн албан хаагчид, Шивээговь, Баянтал, Сүмбэр сумдын Засаг даргын тамгын газрын албан хаагчид, Шивээ-Овоо ХК-ийн ажилчид, Мерси кор ОУБ-ийн зохицуулагч нийт 60 хүнийг хамруулсан сургалт зохион байгуулсан. “Тендерийн баримт бичиг

хэрхэн боловсруулах вэ”, “Тендерт үнэлгээ хэрхэн хийх вэ”, “Зөвлөх үйлчилгээ худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах вэ” зэрэг худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах талаарх сэдвийн хүрээнд уг сургалтыг зохион байгуулж, холбогдох гарын авлага, тараах материалаар хангав.

Тайлант хугацаанд Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Баянгол, Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны 40 гаруй албан хаагчтай уулзан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



тухай хууль"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан архив, албан хэрэг хөтлөлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч өөрийн байгууллагын архивын нэгжийн бүрдүүлэлттэй танилцуулсан. Мөн ХААГ-ын худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод явуулахтай холбогдуулан тохижуулсан өрөө, тасалгаа, техник хэрэгсэл, орчин нөхцөлтэй танилцуулан цаашид орон нутгийн нэгжүүдэд энэ чиглэлээр санаачлан хэрэгжүүлж болох дэвшилттэй санал, саналчилгыг гаргаж ажиллах талаар зөвлөв.

Дараах эрх зүйн баримт бичгийг орон нутгийн нэгжүүдэд хүргүүлэн цаашид үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах талаар зөвлөсөн. Үүнд:

- “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” МУ-ын ЗГ-ын 2014 оны 01 сарын 28-ны өдрийн 49 дүгээр тогтоол,
- “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-д өөрчлөлт оруулах тухай Сангийн сайдын 2014 оны 02 сарын 24-ны өдрийн 32 тоот тушаал,
- “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах тухай” Сангийн сайдын 2014 оны 03 сарын 12-ны өдрийн 49 тоот тушаал,
- МУ-ын ЗГ-ын 2014 оны 03 сарын 28-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл.

Мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн гарын авлагыг 21 аймгийн Худалдан авах ажиллагааны алба бүрт 100 ширхэгийг буюу нийт 2100 ширхэгийг орон нутгийн албад хүргүүлээ.



Дорноговь аймгийн ХААА-ны үйл ажиллагаатай 2014 оны 04 сарын 24-ны өдөр ХААГ-ын дарга Д.Энхжаргал тэргүүтэй удирдах болон гүйцэтгэх ажилтнууд газар дээр нь танилцаж, орон нутаг худалдан авах ажиллагааг зохион байгуулахад тулгамдаж буй асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцаж, зөвлөгөө өгөв.

2014 оны эхний хагас жилийн байдлаар Говь-Алтай, Өмнөговь, Завхан аймгуудын Худалдан авах ажиллагааны албадын дарга чөлөөлөгдөн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч нар томилогдон ажиллаж байгаа ба Говь-Алтай, Өмнөговь аймгуудын Засаг дарга нараас зөвшилцөн томилох санал ирээгүй байна.

Завхан аймгийн Засаг дарга Ж.Жамъянтив тус аймгийн албаны даргад Ж.Сүхбаатарыг нэр дэвшүүлэн зөвшилцөн томилох санал ирүүлсэнд холбогдох хариуг өгөв. Мөн Ж.Сүхбаатарын ажил эрхлэлтийн талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс ирүүлэхийг хүссэний дагуу уг мэдээллийг ХААГ-ын даргын 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 1/977 тоот албан бичгээр хүргүүлсэн.

### 2.4.3. Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах чиглэлээр

Байгууллагын үйл ажиллагааны болон төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийн нээлттэй, илт тод байдлыг хангах, иргэд, олон нийтэд мэдээллийг шуурхай хүргэх асуудалд онцгой анхаарал хандуулан 2014 оны төлөвлөгөөнд

тодорхой ажлуудыг тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэв.

Байгууллагын цахим хуудас [www.e-tender.mn](http://www.e-tender.mn) цахим хуудсын мэдээллийн бүтэц, агуулга, мэдээллийн чанарыг сайжруулах арга хэмжээг аван шинэчлэхээр ажиллаж байна. Худалдан авах ажиллагаанд оролцогч олон улсын байгууллага, иргэдэд хүргэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын цахим хуудсыг англи хэл дээр болгох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах үүднээс ХААГ-т Ил тод байдлын самбар, Захиргаа, удирдлагын хэлтсийн мэдээллийн самбаруудыг ажиллуулж, байгууллагын албан хаагчдад болон тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, олон нийтэд хандсан мэдээ, мэдээллийг бэлтгэн тэдний хүртээл болгож байна.

Худалдан авах ажиллагааны газрын [www.e-tender.mn](http://www.e-tender.mn), Засгийн газрын ХАА-ны [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn), цахим худалдан авах ажиллагааны систем [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn) цахим хуудсуудад худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж байгаа үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны мэдээлэл, үр дүнг байрлуулан олон нийтэд мэдээлж байна. Энэ ажлыг эрчимжүүлэх зорилгоор Газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/69 дүгээр тушаал гарч, тендер шалгаруулалтын үр дүнг тодорхой мэдээлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Ингэснээр тендерт шалгарсан болон шалгараагүй компаниудын тендерийн материалыг ил тод цахим хуудсанд байршуулж байгаа нь олон нийтээс гарах хардлага, буруу, ташаа мэдээллийг багасгаж, тендерт оролцогчдын гаргаж болох гомдол үндэслэлтэй байх, мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болов. Тендерт шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн 81 тендерийн материалыг эхний хагас жилийн байдлаар [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn) цахим хуудсанд байрлуулж, олон нийтэд ил тод мэдээлээд байна.

Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж байгаа тендерийн хяналтын төсвийг цахим хуудсанд ил тод байршуулан олон нийтэд мэдээлж байна. Энэ нь хэт өндөр төсөвтэй тендерийн санал ирж, тендер хүчингүй болохоос сэргийлэх, оролцогчдын үнийн санал хяналтын төсвийн хязгаарын зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү гарахгүй болж байгаа нь улсын төсвийн хөрөнгийг хэмнэхэд чухал ач холбогдолтой санаачилга болов.

Орон нутгийн нэгжүүдийн мэдээллийн ил тод байдал, вэб хуудсын хөгжүүлэлтийн талаар судалгаа хийхэд аймаг бүр өөр өөр загвараар хийсэн байгаа нь иргэд, олон нийтийн мэдээлэл олж авахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байна гэсэн дүгнэлтэд хүрч, нэгжүүдийг нэгдсэн нэг загварын вэб хуудастай болгох саналыг дэвшүүлэн “Цахим 2” төслийн хүрээнд уг асуудлыг шийдвэрлэхээр болсон ба шинээр вэб хуудас хийхээр төлөвлөж байсан албад дээрх төсөл хэрэгжтэл түр хүлээж байна.

ХААГазар болон орон нутгийн ХААА-ын 2014 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 2014 оны 1, 2-р улирлын тайлан зэргийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn), ХААГ-ын [www.e-tender.mn](http://www.e-tender.mn) цахим хуудсанд тус тус байршуулж, мэдээлсэн.

Байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон мэдээ, мэдээллийг өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэдэд хүргэсэн мэдээллийг тоон дүнгээр авч үзвэл, 2014 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар, телевизээр - 27, өдөр тутмын сонингоор - 23, цахим хуудсаар - 16 удаа, нийт 66 удаа байгууллагын



үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн худалдан авах ажиллагааны явцын мэдээ, сурвалжлага, ярилцлагыг нийтлүүлэв.



Тайлант хугацаанд ХААГ-ын үйл ажиллагаа болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүргэх үүднээс [www.e-tender.mn](http://www.e-tender.mn), [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn), [www.zasag.mn](http://www.zasag.mn), [www.vip76.mn](http://www.vip76.mn), [www.facebook.com/procurementmn](https://www.facebook.com/procurementmn) зэрэг цахим хуудсанд мэдээ, мэдээллийг тогтмол оруулж олон нийтийн хүртээл болгож ажиллав.



Зорилтот мэдлэг дээшлүүлэх сургалтын цахим дэлгүүрийн мэдээлэл бүхий хэсгийг "Эх орон" телевиз болон байгууллагын фэйсбук хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна.

Тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлэх ажлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгогдсон өдөр тутмын сонинд тавьж, олны хүртээл болгох зохион байгуулалтын арга хэмжээг авч, 2014 оны 02 дугаар сарын 16-нд ХААГ-аас зарласан тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарыг нийтлэх өдөр тутмын сонинг нээлттэй сонгон шалгаруулсан. Тус сонгон шалгаруулалтанд өдөр тутмын 4 сонин үнийн саналаа ирүүлсэн ба Өдрийн сонин, Зууны мэдээ сонин шалгаран тус агентлагтай хамтран ажиллаж байна.




2

2014 оны 06 дугаар сарын 25-ны байдлаар "Өдрийн сонин", "Зууны мэдээ" сонинд зарласан, дахин зарласан, залруулга хийсэн нийт 175 тендерийн урилга,


зөвлөх үйлчилгээний зар, UB Post сонинд зарласан, дахин зарласан нийт 46 тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарыг англи хэл дээр нийтлүүлсэн байна.

### 2.4.4. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, олон нийттэй харилцах чиглэлээр

Байгууллагын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр иргэд, ААН-тэй харилцан шуурхай үйлчилж ажиллав. 2014 оны эхний хагас жилийн байдлаар “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр нийт 9571 иргэн, ААН-д үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2279-өөр буурсан дүнтэй байна.



Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах болсонтой холбоотойгоор зөвлөгөө өгөх, байгууллага, ААН-д хувийн нууцлалын код олгох үйлчилгээ өссөн.



Байгууллагын үйл ажиллагааг олон нийтийг хамарсан уулзалт, зөвлөгөөн, өдөрлөг, арга хэмжээгээр дамжуулан сурталчилж, төрөөс худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомж, төрийн бодлого, шийдвэрийг иргэд, олон нийт, сонирхогч, хэрэглэгч нарт бодитоор мэдээлэн таниулахад анхаарал хандуулж ажиллав.

“Уламжлалт тендерээс - Ухаалаг тендерт” гар утсанд суурилсан программыг хэрэглээнд нэвтрүүлэх төслийн ажлын даалгаврыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. Энэ ажилд шаардагдах хөрөнгийг Сангийн сайдын багцаас гаргах болсон бөгөөд тус яамны Мэдээлэл, технологийн хэлтсээс уг ажлыг хийхээр болсон.



ХААГ-ын дарга Д.Энхжаргал Засгийн газрын “11-11 төв”-д 2014 оны 05 дугаар 06-ны өдөр ажиллаж, иргэд, олон нийттэй харилцан, ХААГ-аас зохион байгуулж буй ажлын явцын мэдээг мэдээлэхийн хамт худалдан авах ажиллагаатай холбоотой тэдний сонирхсон асуулт, санал хүсэлтэд шууд хариулт өгч, тэдний санаа бодлыг сонсов.

Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвын санаачлагаар Шадар сайдын ажлын алба, МҮХАУТанхим, МАОЭХолбоотой хамтран “Шилэн тендер - 2” арга хэмжээг 2014 оны 01 дүгээр сарын 24-нд ГХЯамны “Зөвшилцөл” танхимд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд худалдан авах ажиллагаанд идэвхтэй оролцдог 250 гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцов.



Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газраас төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд явуулж байгаа бодлого, 2014 оны худалдан авах ажиллагааны онцлог буюу тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах ажлыг олон нийтэд сурталчлан таниулж, худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагуудыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хариуцлагатай, өндөр бүтээмжтэй оролцоход тодорхой мэдээлэл өгсөн ажил болов.



“Шилэн тендер – 2” уулзалт арга хэмжээний үеэр ХААГ болон орон нутгийн 22 нэгжийн 2014 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтыг 150 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, тэдний тендерт оролцох тэгш боломжийг бүрдүүлж, шаардлагатай мэдээллээр хангагдахад дэмжлэг болсон.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 6 агентлагийн удирдах ажилтны “Шуурхай хуралдаан”-ны бэлтгэл ажлыг хангаж, 2014 оны 02 дугаар сарын 24-ний өдөр ХААГ-д зохион байгуулав.



Уг шуурхай хуралдаанаар худалдан авах ажиллагааг цаг тухайд нь шуурхай, чанартай зохион байгуулахад захиалагч байгууллага – Төсвийн ерөнхийлөн захирагчийн байгууллагын шуурхай, хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд Шадар сайдын зүгээс анхаарахаар болов.

2013, 2014 онд зохион байгуулсан, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнг иргэд, олон нийтэд мэдээлэн, таниулах зорилготойгоор Чингисийн талбайд “Ил тод худалдан авалт” нээлттэй өдөрлөгийг 2014 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулав. Тус өдөрлөгт Засгийн газрын агентлаг ХААГ, нийслэлийн ХААГ, 9 дүүргийн ХАА-ны албад, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Төрийн банк, 2013 онд зохион байгуулсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шалгарч, гэрээний үүргээ биелүүлсэн 120 гаруй аж ахуйн нэгж, 20 гаруй иргэдийн бүлэг болон худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулдаг ТББ-ууд зэрэг нийт 150 гаруй байгууллага, ААН оролцов.

*“Ил тод худалдан авалт” нээлттэй өдөрлөгийн багц зургууд*







Уг арга хэмжээ нь Засгийн газраас зарласан “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоног”-ийн хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог байсан төдийгүй тус салбарын хариуцлага, үр дүнгийн манлайллыг олон нийтэд хандуулсан ил тод, нээлттэй, томоохон арга хэмжээ болсон. Өдөрлөгийн үеэр Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газраас Төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд явуулж байгаа бодлогыг сурталчлан таниулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013, 2014 онд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл болон явцын талаар, 2014 онд тус агентлаг, нийслэлийн ХААГ, дүүргүүдийн ХААА-аас зохион байгуулж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авалтын талаар иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өгч, өнгөрсөн онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд шалгарч, гэрээ байгуулсан компаниуд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнгээ иргэд, олон нийтэд тайлагнав.

Тус өдөрлөгийн үеэр худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулдаг "Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв", "Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв", МУИС-ын “Бизнес төв”, “Монголын төвсийн мэргэжилтнүүдийн холбоо” зэрэг төрийн бус байгууллагууд оролцож, 50 %-ийн хөнгөлөлттэй худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтанд хамруулахаар бүртгэж, эхний ээлжийн сургалтыг 2014 оны 06 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд МУИС-ийн Бизнесийн сургууль дээр зохион байгуулсан ба 30 иргэн хамрагдсан. Дүүргийн иргэдийн бүлэг өөрсдийн хийж, гүйцэтгэсэн ажлаа олон нийтэд танилцуулахын зэрэгцээ хоорондоо хийсэн ажлын туршлагаа солилцсон.



“Ил тод худалдан авалт” нээлттэй өдөрлөгийн үеэр ХААГ-ын “Нэг цэгийн үйлчилгээ”, Хуулийн хэлтэс, ЦХААХ-ийн мэргэжилтнүүд өдөрлөгийн үеэр 700-д иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөлд зөвлөгөө өгч ажилласан ба ХААГ, нийслэл, дүүргийн салбар албад, ТББ-аас нийт 3000 гаруй иргэдэд үйлчилсэн байна. Энэ арга хэмжээний ач холбогдол тус арга хэмжээнд оролцсон иргэд, тендерт шалгаран ажил гүйцэтгэж, үр дүнгээ тайлагнасан ААН-үүдийн оролцоо, сэтгэгдэл, хэвлэлд өгсөн ярилцлага, мэдээллээр илэрч байв.

## 2.5. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Худалдан авах ажиллагааны чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, гадаад орнуудын ижил төстэй байгууллагуудын туршлага судлах, албан хаагчдыг өндөр хөгжилтэй орнуудад мэргэшүүлэх талаар анхааран ажиллав.

“Худалдан авах ажиллагааны газрын ил тод байдлыг хангах, чадавхийг бэхжүүлэх” зорилт бүхий дэд төслийг Дэлхийн банкны "Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл"-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Дэд төслийн хүрээнд мэргэжилтнүүдийг чадавхи бэхжүүлэх сургалтанд хамруулж, дотоодын зөвлөхүүдийг гэрээлэн ажиллуулж, цахим тендер шалгаруулалт зохион байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг тус байгууллагын үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг үзүүлж байна. Дэлхийн банкны 300,0 ам долларын техник, туслалцаа үзүүлэх уг төсөл 2014 онд үргэлжлэн хэрэгжиж дуусна.

2014 оны эхний хагас жилд уг төслийн хүрээнд тус газарт Дэлхийн банкны дотоодын 3 зөвлөх тухайлбал, Эрсдлийн удирдлагын чиглэлээр ХШҮДАХ-т 1, Олон нийтийн харилцааны чиглэлээр ССОНХХ-т 3 зөвлөх тус тус ажиллаж байна. Үнэлгээний хороодын гишүүдийн ажиллах нөхцөл, боломжийг дээшлүүлж, цахим худалдан авах ажиллагаанд дэмжлэг үзүүлж, 20 iPad-аар хангах санхүүжүүлтийн асуудлыг шийдвэрлэв.

Тайлант хугацаанд нийт 5 албан хаагчийг гадаад улс оронд сургалтанд хамруулж, төрийн алба, худалдан авах ажиллагаатай танилцуулж, туршлага судлуулах арга хэмжээ авав. Үүнд, Филиппин улсын Манила хотноо Азийн удирдлагын институтын “Стратегийн нээлттэй хөтөлбөр”-ийн “Хэлэлцээр хийх стратеги” сургалтанд 4 албан хаагчийг Дэлхийн банкны олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн “Худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэх дэд төсөл”-ийн санхүүжилтээр, БНСУ-ын Койка Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн дэмжлэгтэйгээр "Төрийн албан хаагчийн чадавхи бэхжүүлэх" сургалтанд БНСУ-д 1 албан хаагчийг тус тус хамруулсан.



"Хэлэлцээр хийх стратеги" сургалт



"Төрийн албан хаагчийн чадавхийг бэхжүүлэх" сургалт

Дэлхийн банкны “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”-ийн хүрээнд тус газарт энэ оны 07 дугаар сараас эхлэн 2 мэргэжилтнийг ажиллуулж,

ХААГ-аас 2013-2014 онд зарласан тендерт гүйцэтгэгчээр шалгарсан компаниудын чадавхийн судалгаа хийж байна. Үүгээр тендерт оролцогч компаниудын чансаа тогтоох тодорхой хэмжээний боломж бий болж, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтийг хэрэгжүүлэхэд ахиц гарах юм.

Цахим худалдан авах ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байгаа Гүрж, Япон, Солонгос, Протугалийн системийг судалсан. Гүрж, Азербайджан улсын Худалдан авах ажиллагааны агентлагуудын англи хэл дээрх сайтын бүтэц, агуулгад судалгаа хийв. ЕСБХБ-тай хамтран ажиллах хүрээнд Цахим дэлгүүрийг ажиллуулах бэлтгэл ажлыг хангах чиглэлээр ЕСБХБ-ны ОУ-ын зөвлөх Пауло Магина, Гүрж улсын ХАА-ны байгууллагын дарга Тато Уржумелашвили нар 4 удаа ирж, ХААГ-т ажиллан судалгаа хийлээ. Сингапур улсын Засгийн газрын ЦХАА-ны тогтолцоотой танилцах, туршлага судлах боломжийг бий болгох талаар ЭСЯ, Шадар сайдад асуудлыг танилцуулж, албан бичгээр санал хүргүүлэв.

БНСУ-ын Самсунг СДС компанийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, системийн хэвийн ажиллагаа, хэрэглээ, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбогдох мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч ажиллав.

Азийн хөгжлийн банктэй хамтран ажиллалаа. Энэ хүрээнд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа ХААГ-ын чадавхийн үнэлгээ хийх зорилгоор АХБ-ны Институцийн чадавхийн хөгжлийн асуудал хариуцсан зөвлөх Бикаш Ранжан Даш тус байгууллагад ажиллаж, үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн ба ХААГ-ын чадавхийг бэхжүүлэх, ирэх 5 жилийн ХААГ-ын стратегийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлж байна. Энэ талаар АХБ-тай цаашид хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр боллоо.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Бизнесийн санаачлагыг дэмжих төслийн удирдагч ХААГ-ын удирдлага, холбогдох бусад албан хаагчидтай уулзан хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх талаар санал солилцлоо. Цаашид тодорхой асуудлаар тус байгууллагаас дэмжлэг авч ажиллахаар болов.

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

### 3.1. УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсын Шадар сайд, түүний ажлын албанаас 2014 оныг “Сахилга, хариуцлага, манлайллыг өндөржүүлэх жил” болгон зарлаж, харьяа 6 агентлагийн дунд “Манлайлагч”-ийг хагас, бүтэн жилээр шалгаруулах болзол гаргасны дагуу тус агентлаг үйл ажиллагаандаа удирдлагын манлайллыг өндөржүүлж, нийт албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд анхааран, байгууллагын хэмжээнд “Бид манлайлна” оны зорилтыг тавин ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна.

Агентлагийн даргын буюу Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний хагас жилийн биелэлтийг Монгол Улсын Шадар сайдаас “А” буюу “Маш сайн” гэж дүгнэж, хагас жилийн ажлын дүнгээр Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний 6 агентлагаас “Шилдэг удирдагч”-тай байгууллагаар шалгарч, батламж гардан авсан нь тус байгууллагын ажлын болон удирдлагын үр дүнгийн үнэлгээ болж байна.

Газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 стратегийн зорилт, 10 хөтөлбөрийн хүрээнд нийт 62 арга хэмжээг тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийн явцыг дүгнэхэд 30 арга хэмжээ нь бүрэн биелсэн, 24 арга хэмжээ хэрэгжих шатанд, 8 арга хэмжээний хугацаа болоогүй буюу тодорхой шалтгааны улмаас хэрэгжих хугацаа хойшлогдон, хүлээгдэж байна. Нийт арга хэмжээний 83,9 % нь 70-100 % хэрэгжиж байгаа буюу



Биелсэн ба төлөвлөгөөний хэрэгжилтийн явц дунджаар 91,1 %-тай байгаа нь оны үлдэж байгаа хугацаанд удааширч болон хүлээгдэж байгаа ажлуудыг анхааран ажиллавал бүрэн хэрэгжих боломжтой байна. Хэлтэс бүр байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэлстийн төлөвлөгөөг сар бүр тодотгон гаргаж, биелэлт, үр дүнг сарын эцэст тооцон ажиллаж байна. Хэлтсүүдийн сарын ажлын биелэлтэд ХШҮДАХ-ээс сар бүр хяналт тавьж байна.

Хэлтсүүдийн ажлын үр дүн, албан хаагчдын эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан хамгаалалтын ажлыг зохион байгуулж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Газрын даргын Б/83 тоот тушаал гаргав. Эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтээр А, В, С үнэлгээ авсан нийт 53 албан хаагчийг холбогдох журамд заасны дагуу Төр, засгийн болон салбарын шагналаар шагнуулахаар тодорхойлох, цалингийн урамшуулал олгох зэргээр шагнаж, урамшуулав.

Байгууллагын даргын зөвлөлийн хурлыг эхний хагас жилд нийт 4 удаа, удирдах ажилтны шуурхай хурлыг нийт 20 удаа зохион байгуулан хуралдуулж, шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, шуурхай хурлаас удирдлагын өгсөн үүрэг чиглэлийг шуурхай хэрэгжүүлэх зохион байгуулалтаар ханган ажиллав.

Байгууллагын менежментийн нэгэн хэсэг болсон Хүний нөөцийн удирдлагын хэрэгжилт, манлайллыг ханган ажиллав. Энэ хүрээнд “Худалдан авах ажиллагааны газрын Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт” баримт бичгийг байгууллагын стратегийн төлөвлөлттэй уялдуулан боловсруулж, батлуулахаар тайлант жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ба баримт бичгийг боловсруулахын тулд Сангийн яам, Гаалийн Ерөнхий газар, Татварын Ерөнхий газар, Хууль зүйн яам зэрэг төрийн байгууллагуудын ижил төстэй баримт бичгийг харьцуулан судалж байна.

Эхний хагас жилийн байдлаар байгууллагын хүний нөөцийн асуудлаар нийт 82 тушаал гарсныг дорх графикаар ангилан харуулав.



Тайлант хугацаанд төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон 17 албан хаагчийг Сар шинийн баяраар Тангараг өргүүлэв. Төрийн албаны шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн 5 албан хаагчийг албан тушаалд томилохоор Төрийн албаны

зөвлөлд хүсэлт гаргаж, дүгнэлтийг үндэслэн Төрийн жинхэнэ албан тушаалд томилов.

Ажлын байрны 3 сул орон тоог төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөөс нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлд гаргаж, шаардлагад нийцсэн 5 иргэнийг бүртгэн авч, 2 иргэнийг туршилтын хугацаагаар түр томилоод байна.

Албан хаагчдын сахилга, хариуцлага, ажлын үр бүтээлийг дээшлүүлэх зорилгоор “Оны шилдэг ажилтан”, “Оны шилдэг хамт олон” шалгаруулах болзол, журмыг боловсруулан баталж, албан хаагчдад сурталчлан мэдээлэв. Жилийн эцэст шилдгүүдийг тодруулна.

Ажлын цаг ашиглалтыг сайжруулах тухай газрын даргын Б/41 тоот тушаал гарган, цаг ашиглалтын байдалд Захиргаанаас хяналт шалгалтыг тогтмол хийж, үр дүнг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох арга хэмжээ авч ажилласнаар байгууллагын хэмжээнд ажлын цаг ашиглалт, сахилга, дэг журам сайжирсан. 2014 оны эхний хагас жилийн байдлаар сахилгын шийтгэл авсан албан хаагч гараагүй.

Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Хүний Нөөцийн Удирдлагын Мэдээллийн Системийн программ /ХНУМСП/-ын дагуу боловсруулж, Төрийн албаны зөвлөлд хуулийн хугацаанд хүргүүлэв.

Байгууллагын зүгээс УИХ-ын гишүүд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайдын ажлын алба, Сангийн яам, бусад төрийн захиргааны төв, орон нутгийн удирдах байгууллагатай харилцан ажиллаж, төрийн худалдан авах ажиллагааг үр дүнтэй, шуурхай зохион байгуулах асуудлаар мэдээлэл солилцон, энэ чиглэлээр тодорхой хүчин чармайлт гарган ажиллав. Тухайлбал, 2014 онд Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж буй орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалт, ажлын явцыг аймаг тус бүрээр ангилан гаргаж, орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүдэд, УИХ-ын гишүүн М.Дэмбэрэл, М.Зоригт, аймгийн Засаг дарга нарт хүргүүлж, зохих мэдээллээр ханган ажилласан. Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарын шуурхай хуралдаанд нийт 6 удаа оролцож, мэдээлэл хийсэн ба Шадар сайдаас өгсөн үүргийг тухай бүр хэрэгжүүлж, эргэн мэдээлж, тайлагнасан. Засгийн газрын “Хэрэгжилт, хяналт, хариуцлага” цахим хуралд худалдан авах ажиллагаатай холбоотой Шинэчлэлийн Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг сар бүр, нийт 6 удаа мэдээлэв. Шадар сайд, ЗГХЭГ-аас шаардсан мэдээ, мэдээллийг цаг тухайд нь боловсруулан хариу мэдээлж ажилласан ба хугацаа хоцроож, тасалсан мэдээ, мэдээлэл гараагүй.

### 3.2. ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ҮР ДҮН

Худалдан авах ажиллагааны газрын зохион байгуулж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явцын мэдээллийн бааз үүсгэн түүний тусламжтайгаар холбогдох мэдээ, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, авах арга хэмжээг тодорхойлох зэргээр ашиглан явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж ажиллаж байна. ХАА-ны явц, үр дүнг хянах мэдээллийн баазыг шинэчлэх асуудлыг боловсруулж байна. Худалдан авах ажиллагааны явц, байгууллагын үйл ажиллагаанд нийт 8 удаа хяналт-шинжилгээ хийж, тухай бүр зөвлөмж өгч ажиллав.

Сангийн сайдын тушаалын дагуу бүртгэлд хамрагдсан аж ахуйн нэгжийн мэдээллийг тухай бүр тус газрын [www.e-tender.mn](http://www.e-tender.mn) вэб хуудсанд байршуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо тендерийн материалаа хуурамчаар бүрдүүлсэн байж болзошгүй нэг компанийн талаарх мэдээллийг Сангийн яаманд албан бичгээр хүргүүлэв. Сангийн яамнаас “хар жагсаалт”-д оруулан бүртгэсэн 27 ААН-ийг зарласан ба түүнд бүртгэлтэй компаниудыг ХААГ-аас зохион байгуулсан худалдан авалтад оролцох боломж олгохгүй байхад хяналт тавин ажиллав.

Худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнд иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгаа, хийж түүнийг үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох талаар анхааран санал хүсэлтийн хайрцаг, цахим хуудсаар болон нээлтэй өдөрлөгийн үеэр иргэдээс санал ирүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллав. 06 дугаар сарын 06-ны өдөр Чингисийн талбайд болсон “Ил тод худалдан авалт” нээлттэй өдөрлөгт оролцогч 200 хүнээс санал асуулгын хуудсаар сэтгэл ханамжийн судалгаа авав. Дээрх сувгаар авсан санал, асуулгын дүнг нэгтгэн цаашид худалдан авах ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнд дүн шинжилгээ хийж байна.

Үнэлгээний хороодын үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангуулж, үнэлгээний ажлыг шуурхайлах, цаг алдахгүй байх тал дээр анхааран холбогдох арга хэмжээг авч ажиллав. Худалдан авах ажиллагааны явц удааширч байгаа төсөл, арга хэмжээнд мониторинг хийн хугацаа алдан удааширч байгаа ажлуудыг эрчимжүүлэх талаар хариуцсан хэлтэс, мэргэжилтнүүдэд анхааруулах шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, ажилласнаар өнгөрсөн онтой харьцуулахад худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулж байгаа ба тендерийн үнэлгээг тендер хүчинтэй байх хугацаанд багтааж аль болох богино хугацаанд хийнэ гэсэн хуулийн заалтын хэрэгжилт сайжирсан. Энэ үр дүнг 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн байдлаарх нийт 118 төсөл, арга хэмжээ буюу 195 багц ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажилласан дүнгээр дор харуулж байна. Нийт ажлын 88,0 %-ийг зохион байгуулан хэрэгжүүлж байгаа, нийт ажлын 63,0 % нь бүрэн биелсэн буюу биелэх шатанд байна. Эдгээрийн хэрэгжилтийн явцыг тодорхой харуулбал,

- Гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн – 123 багц төсөл, арга хэмжээ буюу нийт ажлын 63 %,
- Үнэлгээ хийж байгаа 29 багц ажил буюу нийт ажлын 15 %,
- Тендер зарласан нээх хугацаа болоогүй байгаа 20 багц буюу 11%,
- Зураг, төсөв, ажлын даалгаврыг захиалагч төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлээгүй байгаа 23 багц буюу 12 % байна.


2014 оны ХААГ-ын зохион байгуулсан худалдан авах ажиллагааны үр дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулсан дүнг дор хүснэгтээр буюу графикаар үзүүлбэл,

#### Ажлын үр дүнгийн харьцуулсан үзүүлэлт

Он/Үзүүлэлт	Нийт ажил		Тендер шалгаруулалт зохион байгуулсан		Гэрээ байгуулсан	
	Ажлын тоо	Багцын тоо	Багцын тоо	Хувиар	Багцын тоо	Хувиар
2013 он (07.01-ны байдлаар)	346	569	312	54,8	138	24,2
2014 он (06.16-ны байдлаар)	118	195	172	88,2	124	63,0

Тендер шалгаруулсан ажлын үзүүлэлтийн ахиц, өөрчлөлтийг нийт ажилд ногдох хувиар, мөн гэрээ байгуулсан үр дүнгийн өсөлт, бууралтыг нийт зохион байгуулах багц ажилд ногдох хувиар дүгнэхэд эхний хагас жилийн тендер шалгаруулалт зохион байгуулсан ажлын хувь өмнөх оноос 33,4 %-иар ахисан, гэрээ байгуулсан үр дүн өмнөх оны мөн үеэс 38,8 %-иар өссөн, өмнөх жилээс үр дүн ахисан түвшинд дүгнэгдэж байгаа ололттой байна.

*Нийт ажилд ногдох үр дүнгийн үзүүлэлтийн харьцуулалт, хувиар*



Худалдан авах ажиллагааны газар нь 2014 оны эхний хагас жилийн байдлаар зохион байгуулсан 134,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 124 багц ажлын худалдан авах ажиллагааны гэрээг 130,3 тэрбум төгрөгийн үнийн дүнтэйгээр байгуулж, 3,9 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгийн хэмнэлтийг гаргасан дүнтэй байна.

2014 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тайлант хугацаанд нийт 137 төсөл, арга хэмжээний 130 үнэлгээний хороо байгуулагдаж, тушаал гаргасан ба 26 үнэлгээний хорооны тушаалд өөрчлөлт орсон. Үнэлгээний хороодын үйл ажиллагаа, хугацаа алдаж байгаа болон гэрээ байгуулсан мэдэгдэл хүргүүлсэн, гомдол гарсан ажлуудад хяналт хийж, дүгнэлт гарган, удааширч байгаа, анхаарах ажлуудын судалгааг үнэлгээний хорооны дарга, нарийн бичиг тус бүрээр нь гарган нийт албан хаагчдад танилцуулж ажилласнаар ажлын хариуцлага дээшилсэн.

ХААГ-ын даргын тушаалаар батлагдсан тендерийн баримт бичгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хамгаалах зорилгоор батлагдсан өдөр нь лацдаж байгаа нь батлагдсан тендерийн баримт бичигт өөрчлөлт орох, аюулгүй байдлыг хангах баталгаа болж байна.

Худалдан авах ажиллагаанд гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж хэрэгжилтийг хангахад Олон улсын байгууллагын мэргэжлийн дэмжлэг авч ажиллаж байна. Энэ хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийхээр Дэлхийн банкны дотоодын зөвлөхийг урьж, ажиллуулан хамтран ажиллаж, ХААГ-ын эрсдэл, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлын, төлөвлөгөөг боловсруулж байна.

### 3.3. БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх ажлын

нэгдсэн төлөвлөгөөг тус тус батлуулан хэрэгжилтийг оны эхнээс ханган ажиллаж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 27 заалтыг тусган хэрэгжүүлж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар хэрэгжилтийн явц 86,3 %, харин Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд нийт 10 заалтыг тусган хэрэгжүүлж байгаа нь хагас жилийн байдлаар 74,0 %-ийн явцтай байна.

*Авлигын эсрэг үйл ажиллагаа, Сургалт, соён гэгээрүүлэх ажлын  
төлөвлөгөөний биелэлт*

№	Хэрэгжилтийн явц	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө	Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө
1	Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	27	10
2	Бүрэн хэрэгжиж биелсэн – /Б/	15	2
3	Хэрэгжих шатандаа - /ХШ/	9	3
	Үүнээс: 90 %	4	1
	70 %	2	-
	50%	-	1
	30%	2	1
	10%	1	-
4	Хэрэгжүүлэх хугацаа болоогүй хүлээгдэж байгаа - /ХБ/	3	5
5	Тасарсан - /Т/	-	-
<b>Хэрэгжилтийн хувь</b>		<b>86,3 %</b>	<b>74,0 %</b>

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэх шатанд АТГ-тай хамтран ажиллаж, УССГХ-ийн санал, дэмжлэг, арга зүйн туслалцааг авч ажиллав. Мөн мэдүүлэг бүрдүүлэлтийн чиглэлээр АТГ-ын Хяналт, шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлэг бүрдүүлэлтийн албатай байнга холбоотой байж, мэргэжил, аргазүйн дэмжлэг, туслалцаа авч ажиллалаа.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн бүртгэл хөтлөн хугацаатай бичиг болон зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллахад анхаарав. Эхний хагас жилийн байдлаар АТГ-аас нийт 13 албан бичиг ирснийг бүртгэн авч, хариутай 4 бичигт хариуг шуурхай өгсөн ба тайлант хугацаанд АТГ-аас зөвлөмж ирээгүй. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль, түүнийг хэрэгжүүлж ажиллах тухай чиглэлийг албан бичгээр ирүүлснийг нийт ажилтнуудад дотоод сүлжээ, мэдээллийн самбар, нийт ажилтнуудын хурал, удирдлагын шуурхай хурал зэргээр дамжуулан мэдээлсэн.

Тайлант жилийн 02 дугаар сарын 15-ны дотор (хуулийн хугацаанд) байгууллагын мэдүүлэг гаргагч 49 албан хаагчийн 2013 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргуулан мэдүүлэх ажлыг хууль журмын дагуу зохион байгуулав. Улмаар 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хуулийн хугацаанд багтааж 2013 оны мэдэгдэл, мэдүүлгийн бүрдүүлэлт, ЭБАТ-ын ажлын тайланг гарган АТГ-т хүргэж мэдээлсэн.

2014 оны мэдүүлэг, мэдэгдэл гаргах үйл явцад хяналт тавин ажиллаж, Нийтийн албан хаагчийн мэдүүлэг бүрдүүлэлтийн meduuleg.iaас.mn цахим систем дэх ЭБАТ-ын бүртгэлүүдийг хууль, журам, зааврын дагуу тухай бүр хөтөлснөөр шаардлагатай бүртгэл-мэдээллийн сан үүсч байна. Он гарсаар албан тушаалд шинээр нэр дэвшигч 6 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулан, зохих шийдвэрийг гаргав. 2014 он гарсаар 07-р сарын 20-ны байдлаар нийт 65 үнэлгээний хороонд ажилласан албан хаагчид, ТББ-ын төлөөллөөс ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх 1002 мэдэгдлийг хүлээн



авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүртгэсэн ба тэдгээрээс ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол гараагүй.

Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомж, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг байгууллагын албан хаагчдад мэдээллийн самбар, дотоод сүлжээ, удирдлагын шуурхай хурал, нийт ажилтнуудын хурал ба биечлэн зөвлөгөө, зөвлөмж өгөх зэрэг сувгаар дамжуулан сурталчлан таниулах арга хэмжээ авч, мөрдөн хэрэгжүүлж ажиллав. УИХ-аас 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу хөрөнгө орлогодоо орсон их хэмжээний өөрчлөлтийг 3 албан хаагч мэдээлсэн бол шинээр албан тушаалд томилогдсон 5 албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ-ыг шинээр мэдүүлэв.

Орон нутгийн ХАА-ны нэгжүүдэд салбар ЭБАТ үүсгэх асуудлыг АТГ-ын холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцаж, АТГ-аас орон нутагт чиглэл өгөхөөр болсны дагуу 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан төв, орон нутгийн ЭБАТ-уудын нэгдсэн семинар дээр АТГ-аас чиглэл өгсөн. Аймгийн ЗДТГ-ын Эрх бүхий албан тушаалтнаас салбар ЭБАТ-ын эрх үүсгэн үнэлгээний хорооны гишүүдийн гаргасан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг АТГ-ын мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд оруулах талаар ХААГ-аас Орон нутгийн нэгжүүдэд хандаж мөн чиглэл өгсөн. Үүний дагуу 2014 оны эхний хагас жилийн байдлаар 31 нэгжээс 26 газар, алба Аймгуудын ЗДТГ дахь аймгийн ерөнхий ЭБАТ-аас салбар ЭБАТ-ын эрхийг тус бүр үүсгэн ажиллаж байгаа бөгөөд 5 алба аймгийн ЗДТГ-ын ЭБАТ-аар үнэлгээний хорооны гишүүдийн гаргасан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг цахим мэдүүлэг бүрдүүлэлтийн системд оруулах ажлыг гүйцэтгүүлж байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг албан тушаалтнуудад таниулах, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор АТГазар, АНУ-ын Азийн сан, “Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд, хөдөлгөөн” ТББ-тай хамтран 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр ХААГ-ын нийт 49 албан хаагчдад сургалт зохион байгуулж, холбогдох гарын авлага, материалаар хангав.



“Ил тод худалдан авах ажиллагаа” шийдвэр гаргах түвшний зөвлөлдөх уулзалтыг АТГ, АНУ-ын Азийн сан ОУ-ын байгууллагатай хамтран зохион байгуулахаар бэлтгэл хангасан боловч ШСАА-аас тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

Эрсдэлтэй ажлын байрны судалгааг хийхэд хамтран ажиллах талаар 05-р сарын 01-ний өдөр Хараат бус судалгааны төв /IRIM/ ТББ-тай санал солилцсон

бөгөөд тус ТББ-аас санал болгосон судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг хүлээн авсан боловч санхүүжүүлэх эх үүсвэргүйгээс тодорхой шийдвэр гараагүй байна. Санхүүжилтийн асуудлаар Азийн санд санал тавьсан ч боломжгүй тухай хариу авсан.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээлэл хүлээн авах хайрцаг ажиллууж, мэдээллийн мөрөөр арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөсөн ба эхний хагас жилд хайрцагаар ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээлэл үгүй байна. “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн холбогдох заалтад Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг олон нийтэд мэдээлэх тухай заасны дагуу тус байгууллагад одоогоор мэдээлэх шаардлагатай этгээд байхгүй байна.

### **3.4. АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ТЭДНИЙ НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР**

“ХААГ-ын албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд 3-р сард Хүний хөгжлийн “Оюуны чадавхи” төвөөс сургагч багш урьж, “Багийн ажиллагаа” сэдэвт сургалт, 5-р сард Удирдлагын академийн Төрийн удирдлагын тэнхимийн багш, доктор Ж.Цолмонтаяаг урьж, “Төрийн албаны ёс зүй” сэдвээр албан хаагчдад лекц уншуулж, сургалт зохион байгуулав.

Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Төрийн албаны институтын Төрийн албан хаагчийн чадавхийг дээшлүүлэх 1 өдрийн сертификаттай сургалтад 6 албан хаагч, Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтын сургалтанд 3 албан хаагч тус тус хамрагдаж, сертификат авав. Удирдлагын Академийн Төрийн удирдлагын Магистрын “гараг”-ийн сургалтанд 1, Төрийн удирдлагаар мэргэшүүлэх “гараг”-ийн сургалтад 2 албан хаагчийг тус тус суралцуулахаар сонгон шалгаруулж, материалыг бүрдүүлэн хүргүүлээд байна.

Эхний хагас жилд 4 албан хаагч Филиппин улсад худалдан авах ажиллагааны чиглэлээр 7 хоногийн сургалтанд, 1 албан хаагч БНСУ-ын “KOICA” байгууллагын шугамаар төрийн захиргааны чиглэлээр 14 хоногийн сургалтанд тус тус хамрагдав.

“ХААГ-ын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд албан хаагчдын цалин хөлсийг хуулийн хүрээнд нэмэгдүүлэх боломж нөхцлийг судалж тооцоо судалгааг хийж, асуудлыг Даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн нийт 48 албан хаагчийн цалин хөлсийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхээр шийдвэрлэв. Үүнд: Үр дүнгийн гэрээний үнэлгээг үндэслэн 27 албан хаагчийн цалингийн шатлалыг ахиулж, 5 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ТҮ ангиллын 7 албан хаагчид ур чадварын нэмэгдлийг 2-р сарын 01-нээс олгож эхэлсэн. Болзол шаардлагыг хангаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгуулах, зэрэг дэвийг ахиулах саналыг эрхэлсэн сайдад тавьсны дүнд, 4 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 7 албан хаагчид зэрэг дэв шинээр олгож, зохих нэмэгдлүүдийг олгож эхэлсэн. 1 албан хаагчид ажил үүрэг хавсарсны нэмэгдлийг шинээр олгохоор шийдвэрлэв.

Албан хаагчдын ажиллах, амрах тав тухтай орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Цайны өрөөг иж бүрэн тоноглож тохижуулан ашиглаж байна.

Орон сууцны дэмжлэг хүссэн ажилтнуудын 10 гаруй өргөдлийг хүлээн авч, “Буянт–Ухаа 1” хорооллын орон сууцанд төрийн байгууллагуудад квотод тус байгууллагыг хамруулж, дэмжлэг үзүүлэх талаар Төрийн Орон Сууцны Корпорацид 1/204 тоот, ШСAA-нд 1/239 тоот албан бичгийг тус тус хүргүүлэв.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, дэмжлэг үзүүлэх хүрээнд байгууллагын дотоод журамд заасны дагуу гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 4 албан хаагчид тус бүр 100.0 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал тохиолдсон 2 албан хаагчид тус бүр 300.0 мянган төгрөг, хүндээр өвдсөн 1 албан хаагчид нэг сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж, 3 сарын цалинтай чөлөөг олгосон бөгөөд нийтдээ 7 албан хаагчид 1.5 сая төгрөгийн тэтгэмж, дэмжлэг, тусламж олгосон дүнтэй байна. Эх үрсийн баяраар албан хаагчдын нийт 90 хүүхдэд бэлэг бэлтгэн өгч, спортын өндөр амжилт гаргасан 1 хүүхдэд 100,0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгож, баярын арга хэмжээг зохион байгуулав.

Хамт олныг хамарсан баяр, ёслолын арга хэмжээ (Шинэ жилийн баяр, Сар шинийн золголт, Мартын 8, Цэргийн баяр, Эх үрсийн баяр)-г тухай бүр зохион байгуулж, хамт олны эв нэгдэл, хамтач байдал, нийгмийн идэвхийг дээшлүүлж ажиллав. Мөн Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, амьдрал зөв дадал хэвшлийг бий болгоход анхааран ажиллаж, тодорхой ажлуудыг байгууллагын зүгээс санаачлан хамт олныг хамруулж байна. Тухайлбал, Цасны баярыг Олон улсын Найрамдал төвд 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, албан хаагчдыг эрүүл агаарт идэвхтэй амрааж, өвлийн спортын төрөл бүрийн уралдаан-тэмцээнийг зохион байгуулав.

ГЕГ-ын заалыг Даваа гариг бүрт 2 цагаар түрээсэлж, албан хаагчдад спортоор хичээллэх, бие бялдраа чийрэгжүүлэх нөхцөл боломжоор хангаж, байгууллагын спорт хамтлагийн санал, санаачилгыг дэмжин ажиллав.

Байгууллагын шатар, даамны аварга шалгаруулах тэмцээн, Онцгой байдлын албаны 10 жилийн ойн нэрэмжит спортын уралдаан тэмцээнүүдэд хамт олны багийг зохион байгуулан хамруулав.

Эх үрсийн баяраар албан хаагчдын хүүхдүүдийг хамарсан урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулан 90 хүүхдэд бэлэг өгч, хамгийн олон хүүхэдтэй ээж, хамгийн олон хүүхэдтэй аавыг тодруулан дурсгалын зүйл гардуулж, спортын өндөр амжилт гаргасан хүүхдэд урамшуулал олгосон нь албан хаагчдын гэр бүлийн хөгжлийг дэмжсэн арга хэмжээ боллоо.

### **3.5. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТАЛААР**

Байгууллагын архивын ажлын хүрээнд “Архив, албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/68 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байгаа ба БНШК-ыг хуралдуулан 2014 оны Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг батлуулж, хэлтэс, албан хаагчдад хүргүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын архивт архивын заавар, журмын дагуу дараах хадгаламжийн нэгжүүдийг бүртгэлээр хүлээн авав:


- 2013 оны гэрээ байгуулсан 73 ажлын 165 байнга, 204 түр хадгалах хадгаламжийн нэгж,
- Тодотголоор хасагдсан 49 ажлын 198 хадгаламжийн нэгж,
- 2013 онд үүссэн баримтын байнга хадгалах 261, түр халгалах 402 хадгаламжийн нэгж,
- Тендерийн баримт бичгийн хуулбар хувь - 16 ажлын 333 ширхэг,
- 2014 оны 14 гэрээний 15 ширхэг хадгаламжийн нэгж,
- 2014 онд үүссэн баримтын байнга хадгалах 15 ширхэг хадгаламжийн нэгж.

Хүлээж авсан хадгаламжийн нэгжүүдээс 438 ширхэг хадгаламжийн нэгжийг хавтаслаж, 450 ширхэг хадгаламжийн нэгжийг үдэж хавтаслах бэлтгэлийг хангав.

Байгууллагын архиваас Сангийн яамны шалгалтын комисст болон албан хаагчдын ажлын хэрэгцээнд зориулж, байнга хадгалах 248 хадгаламжийн нэгж, түр хадгалах 190 хадгаламжийн нэгжийг ашиглуулахаар ашиглалтанд бүртгэж гаргасан.

2014 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд нийт 237 тушаал гарсан.

Мөн Яамдын сайд, Агентлагийн дарга нарын төсвийн багцаас санхүүжүүлж, 2014 онд ХААГ-ын зохион байгуулах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан хамтарсан тушаалыг 12 сайд, 4 агентлагийн даргатай байгуулж албажуулав.




Байгууллагын албан хаагчид болон иргэдээс нийт 32 өргөдлийг бичгээр хүлээн авч, хуулийн хугацаанд нь 27 өргөдлийг шийдвэрлэн хариу өгч ажилласан бөгөөд холбогдох хуулинд зааснаар шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал (санхүүгийн болон орон сууцны асуудал)-аар гаргасан 4 өргөдлийг Хүний нөөцийн мэргэжилтэн тусгай бүртгэлд бүртгэн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

*Ирсэн өргөдөл, гомдлын агуулга, бүтцийн судалгаа*


Огноо: 2014/01/01 - 2014/06/16

№	Агуулга	Бичгээр	Цахим	Нийт	Нийт өргөдөлтэй харьцуулсан
1	Орон сууцны хөнгөлттэй зээлд хамрагдах	7	-	7	21.8%
2	Санхүүгийн дэмжлэг хүсэх тухай	4	-	4	12,5%
3	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлүүлэх тухай хүсэлт	9	-	9	28%
4	Ажлаас чөлөөлөгдөх тухай хүсэлт	2	-	2	6.2%
5	Худалдан авах үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар	3	-	3	9.3%
6	Бусад асуудлаар	7	-	7	21.8 %
	<b>Нийт</b>	<b>32</b>	<b>-</b>	<b>32</b>	<b>100 %</b>


Харилцсан бичгийн эргэлтийг авч үзвэл, эхний хагас жилийн байдлаар нийт 1409 албан бичиг ирснээс хугацаанд нь шийдвэрлэсэн ба хариутай 148, холбогдох байгууллагад уламжилсан албан бичиг 120 байсан ба тус байгууллагаас бусад байгууллага, ААН-д явуулсан 1800 албан бичиг гарсан дүнтэй байна.



**Засгийн газрын "11-11 төв"-д** 2014 оны эхний хагас жилийн байдлаар худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар 32 санал, гомдол, шүүмжлэлийг хүлээн авч, 2 саналыг харьяаллын дагуу шилжүүлж, 30 санал, хүсэлт, гомдол, шүүмжлэлд хариу өгөв.



Албан хэрэг хөтлөлт, архивын ерөнхий мэдлэгийг шалгах сорилын ажлыг 6 дугаар сард зохион байгуулсан ба түүнд 8 хэлтсийн нийт 42 албан хаагч хамрагдав. Сорилд хамрагдсан нийт албан хаагчдын мэдлэгийн дундаж үнэлгээ 9,3 буюу 74,0 %-ийн үзүүлэлттэй дүгнэгдэв.



Сорилын мөрөөр авсан арга хэмжээ:

- Зөв хариулт бүхий сорилыг хэлтсүүдэд тараасан.
- Нийтлэг гаргасан алдаа буюу Төрийн хэлний зөвлөлийн “Кирил бичлэгийн стандарт тогтоох тухай” тогтоол, баримт бичгийн шийдвэрлэх хугацааны талаарх мэдээллийг бэлтгэн “Бичиг хэргийн булан”-д байршуулан мэдээлэв.



### 3.6. БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨВ, САНХҮҮ, АЖ АХУЙН АЖЛЫН ТАЛААР

Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, төсөв, хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангаж ажиллахад анхааран ажиллав.

Энэ хүрээнд 2013 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийсэн ба тус байгууллагын санхүүгийн байдал зөрчилгүй гэрчлэгдсэн.

Төсвийн байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагааг “Шилэн дансны тогтолцоо”-нд шилжүүлж байгаатай холбогдуулан байгууллагын [www.e-tender.mn](http://www.e-tender.mn) цахим хуудсанд “Шилэн данс” цэсийг шинээр үүсгэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллав. Санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж холбогдох газарт хүргүүлэн мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод байршуулан мэдээлэв.

**Үндсэн үйл ажиллагааны орлого:** Тайлант хугацаанд тендерийн баримт бичиг худалдсаны орлого 42,5 сая төгрөгийн, үндсэн бус үйл ажиллагааны орлого буюу түрээсийн орлого 2,3 сая төгрөг, нийт 45,8 сая төгрөгийн орлого бүрдүүлэв.

**Авлага:** 2013 оны эцэст 1,1 сая төгрөгийн авлагатай байсан бол тайлант хугацааны эцэст авлагагүй гарсан. **Өглөг:** 2014 оны эхэнд 12,2 сая төгрөгийн өглөгтэй байсан бол тайлант хугацаанд 10,2 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй буюу өмнөх оноос 2,0 сая төгрөгөөр буурсан байна. 2014 оны жилийн эцэст өглөггүй гарах зорилт тавин сүүлийн хагас жилд өглөгийг барагдуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зорилгоор дэд дарга нарын машин унах эрхийг зогсоож, удирдлагын утасны төлбөрийг тогтоосон хязгаарт багтааж байх журмыг мөрдөн зохих арга хэмжээ авч ажиллав.

Байгууллагын өмч хамгаалах комиссын бүрэлдэхүүнийг томилж, комиссын ажиллах журмыг батлан мөрдүүлж эхэлсэн бөгөөд эд хөрөнгө, өмчийн тооллогыг хагас, бүтэн жилд хийв.

Ажилтан албан хаагчдын цэвэр орчин, тав тухтай ажиллах нөхцлөөр хангаж ажиллан цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэсэн. Албан хаагчдыг ажил хэргийн шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр, үйлчлэгчдийг шаардлагатай цэвэрлэгээний материалаар тухайн сард нь тогтмол хангаж байна.

Ажилтан албан хаагчдын цэвэр, тав тухтай ажиллах орчинг бүрдүүлснээр албан хаагчид сэтгэл ханамжтай ажиллаж байгаа нь үйлчлэгч нарын ажил, үйлчилгээтэй холбоотой ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанаас дүгнэгдэж байна.

## ДҮГНЭЛТ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газар нь 2014 оны эхний хагас жилд сахилга, хариуцлага, манлайллыг өндөржүүлж, худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн тодорхой амжилт гарган ажиллалаа.

Орон нутгийн Худалдан авах ажиллагааны албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж, тэдэнд зөвлөгөө дэмжлэгийг өгч, эргэх холбоо үүсгэн ажиллав.

Худалдан авах ажиллагаанд оролцогч ААН, хамтран ажилладаг төрийн байгууллагуудтай мэдээлэл, солилцож, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхааран ажилласан төдийгүй олон улсын байгууллагын дэмжлэг, туслалцааг авч, үнэлгээ, судалгааны ажлуудыг хийлгэж, түүний мөрөөр худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлов.

Худалдан авах ажиллагааг ил тод, шударга, олон нийтийн хяналттай зохион байгуулах үүднээс Үнэлгээний хороонд оролцогч ХААГ-ын ажилтан, ТББ-ын төлөөллийг тухайн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд сонгохдоо санамсаргүй түүврийн аргыг хэрэглэн сонгох, тендерт шалгарсан компанийн тендерт оролцсон материалыг цахим хуудсанд ил тод байршуулах, мөн тендерийн хяналтын төсвийг ил тод мэдээлэх зэрэг арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлж байна.

Ажилтан, албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга, дотоод зохион байгуулалтыг сайжруулахад онцгой анхааран ажилласны дүнд сахилгын зөрчил, доголдолгүй ажиллав.

ХААГ-т зохион байгуулагдаж байгаа тендер шалгаруулалтыг 100 % цахим хэлбэрээр зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тодорхой ахиц дэвшил гаргалаа. 2014 онд ХААГ-т зохион байгуулахаар төлөвлөгдсөн нийт худалдан авах ажиллагааны явц хагас жилийн байдлаар 93,0 %-тай байгаа нь үлдсэн хугацаанд төлөвлөгөөт худалдан авалт 100 % зохион байгуулагдаж дуусах бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, бусад төлөвлөн хэрэгжүүлж байгаа ажлуудын хагас жилийн биелэлт дунджаар 70%-90%-ийн гүйцэтгэлтэй дүгнэгдэж байгаа нь тайлант оны сүүлийн хагас жилд төлөвлөсөн ажил, зорьсон зорилтдоо бүрэн хүрэх боломжтой байна.

Энэхүү тайлангийн дүгнэлт, ажлын үр дүнгийн мэдээлэлтэй дараахь материалууд салшгүй холбоотой гэж үзэж хавсаргав.

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газрын сахилга, хариуцлага, манлайллыг өндөржүүлэх чиглэлээр хийсэн онцлох ажил, үр дүн,
2. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт,
3. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ,
4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт,

**ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ**

Сүүлийн хагас жилд анхаарах асуудлуудыг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, бусад батлагдсан төлөвлөгөөний удааширч байгаа заалтуудыг анхааран шуурхай хэрэгжүүлэх,
2. Бодлогын баримт бичиг болон дээд шатны байгууллагын шийдвэрийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахад анхаарах,
3. Зохион байгуулалт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхайлах,
4. Байгууллагын цахим хуудасны шинэчлэлийн ажлыг шуурхай дуусгаж, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах арга хэмжээг авах,
5. Худалдан авах ажиллагааны явцын мэдээллийн баазыг боловсронгуй болгоход ахиц гаргах.

ТАНИЛЦСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Ч.ЖАРГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ